

БАТЛАВ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
БРИГАДЫН ГЕНЕРАЛ Д.ГАНХУЯГ

2025 оны 22 дугаар сарын 11 -ны өдөр

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ 2025 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨӨЛӨГӨӨ

д/д	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Шаардлагатай төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин /2024/	Зорилтот түвшин /хэрэгжих дуусах хугацаа/	Хугацаа	Хариуцах нэгж
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх.							
1.1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг алба хаагчдад сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах	Үйл ажиллагааны зардлаар	Сурталчилгаанд хамрагдсан алба хаагчдын хувь	2024 онд яам, харьяа байгууллагын хэмжээнд Авлигын эсрэг хууль тогтоомжийг 4 удаа зохион байгуулсан.	<p>Хагас жилийн байдлаар: Яамны харьяа 3 байгууллагын алба хаагчдад Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байна.</p> <p>Жилийн эцсийн байдлаар: Яамны харьяа 6 байгууллагын алба хаагчдад Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байна.</p>	I-IV улиралд	Яам, харьяа байгууллагын Эрх бүхий албан тушаалтнууд
1.2	Батлан хамгаалах яамны харьяа Соёмбо редакцаас эрхлэн гаргадаг нэвтрүүлэг, сонин, сэтгүүл зэргээр дамжуулан Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, авлигын хор хөнөөлийг ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд	Үйл ажиллагааны зардлаар	Сурталчилгаа нийтэлсэн хувь	2024 онд Авлигын эсрэг 1 контент бүтээж олон нийтэд хүргэсэн.	<p>Хагас жилийн байдлаар: Сурталчилгааны ажлыг нэвтрүүлэг, сонин, сэтгүүлээр дамжуулан 4 удаа сурталчилсан байна.</p> <p>Жилийн эцсийн байдлаар: Сурталчилгааны ажлыг нэвтрүүлэг, сонин, сэтгүүлээр дамжуулан 8 удаа сурталчилсан байна.</p>	I-IV улиралд	Соёмбо редакц

1	2	3	4	5	6	7	8
	уриалсан мэдээлэл болон авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх 110 дугаар, Товш апплейкшн, яамны 1800-1144 дугаар зэргийг сурталчлах						
1.3	Авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх видео бичлэг, контент, рийл зэргийг хийж цахим хаягаар сурталчлах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны зардлаар	Видео бичлэг, контент, рийл зэргийн хандалтын хувь	2024 онд Авлигын эсрэг 1 контент бүтээж олон нийтэд хүргэсэн.	<p>Нэгдүгээр улирлын байдлаар: УБХИС-ийн сонсогчдыг оролцуулан Авлигын эсрэг рийл хийж 1 удаа цахим хаягаар түгээсэн байна.</p> <p>Хоёрдугаар улирлын байдлаар: Цэргийн төв эмнэлгийн эмч нарыг оролцуулсан Контент бүтээж 1 удаа цахим хаягаар түгээсэн байна.</p> <p>Гуравдугаар улирлын байдлаар: ЦДБЭЧ-ын уран бүтээлч оролцуулсан контент хийж 1 удаа цахим хаягаар түгээсэн байна.</p> <p>Дөрөвдүгээр улирлын байдлаар: Алдар спорт хорооны алдартныг оролцуулсан Авлигын эсрэг рийл хийж 1 удаа цахим хаягаар түгээсэн байна.</p>	I-IV улиралд	Соёмбо редакц, алба хаагчдыг оролцуулах байгууллагууд
1.4	Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг яамны харьяа байгууллагууд албан ёсны цахим хуудас,	Үйл ажиллагааны зардлаар	Цахим хуудасны хандалтын хувь болон бусад сурталчилсан тоо	Байгууллагууд цахим хуудсаар болон байгууллагын сурталчилгааны самбар зэргээр олон нийтэд хүргэж байсан.	<p>Хагас жилийн байдлаар: АТГ-аас бэлтгэсэн контент болон бусад хэлбэрийн сурталчилгааны ажлыг байгууллага бүр 4 удаа зохион байгуулсан байна.</p>	I-IV улиралд	Яамны харьяа байгууллагууд

1	2	3	4	5	6	7	8
	байгууллагын дотоод сүлжээ, лед дэлгэц, сурталчилгааны самбар болон бусад хэлбэрээр сурталчлах				Цахим хандалтын хувь ёссэн байна. Жилийн эцсийн байдлаар: АТГ-аас бэлтгэсэн контент болон бусад хэлбэрийн сурталчилгааны ажлыг байгууллага бүр 8 удаа зохион байгуулсан байна. Цахим хандалтын хувь ёссэн байна. Сурталчилсан талаарх нотлох баримт, тоог гаргаж хагас бүтэн жилээр ирүүлсэн байна.		
Хоёр. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах							
2.1	Батлан хамгаалах яамны удирдах бүрэлдэхүүн (хэлтсийн даргаас дээш), яамны харьяа байгууллагын дарга нарт Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаарх сургалтыг зохион байгуулах	Үйл ажиллагааны зардлаар	Сургалтад хамруулсан удирдах бүрэлдэхүүний тоо	2024 онд БХЯ, ЗХЖШ-ын удирдах бүрэлдэхүүнийг хамруулсан сургалтыг 1 удаа зохион байгуулсан.	Нэгдүгээр улирлын байдлаар: Яам, харьяа байгууллагын удирдах бүрэлдэхүүнийг сургалтад хамруулсан байна.	I улиралд	БХЕХШ-ийн Ажлын алба, яамны Эрх бүхий албан тушаалтан
2.2	Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах цахим болон танхимиын сургалтад алба хаагчдыг хамруулах	Үйл ажиллагааны зардлаар	Сургалтад хамруулсан алба хаагчдын тоо	2024 онд цахим сургалтад 15 алба хаагч, сургагч багшийн дамжаанд 7 алба хаагчдыг бүрэн хамрагдсан.	Жилийн эцсийн байдлаар: АТГ-аас зохион байгуулсан сургалтад алба хаагчдыг бүрэн хамруулсан байна.	I-IV улиралд	Яам, харьяа байгууллагын Эрх бүхий албан тушаалтууд

1	2	3	4	5	6	7	8
2.3	"Оюутан цэрэг" хөтөлбөрт хамрагдаж байгаа залууст Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар сургалт зохион байгуулах	Үйл ажиллагааны зардлаар	Сургалтад хамруулсан алба хаагчдын тоо	2024 онд "Оюутан цэрэг" хөтөлбөрт хамрагдаж байгаа залууст Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар сургалт зохион байгуулаагүй.	Гуравдугаар улирлын байдлаар: Улаанбаатар цэргийн хүрээнд Оюутан цэрэг хөтөлбөрт хамрагдаж байгаа алба хаагчдад сургалт зохион байгуулсан байна.	III улиралд	Яамны ОНХДГ
2.4	АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран яам, харьяа байгууллагын алба хаагчдад Авлигын эсрэг сургалтын зохион байгуулах	Үйл ажиллагааны зардлаар	Сургалтад хамруулсан алба хаагчдын тоо	2024 онд Яам, харьяа байгууллагын нийт 170 гаруй алба хаагчдад сургалт зохион байгуулсан.	Нэгдүгээр улирлын байдлаар: ҮБХИС-ийн БХУА-ийн албан тушаалын дамжааны бүрэлдэхүүн, БХЭШХ-ийн алба хаагчдыг сургалтад хамруулсан байна. Хоёрдугаар улирлын байдлаар: ЦДБЭЧ, БХТА, Зэв УТҮГ-ын алба хаагчдыг сургалтад хамруулсан байна. Гуравдугаар улирлын байдлаар: ЦТЭ, МЦМ, YAAX-ийн алба хаагчдыг сургалтад хамруулсан байна. Дөрөвдүгээр улирлын байдлаар: Бөртэ ТӨААТҮГ, БХАҮН ТӨААТҮГ, Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ, Багабаян-Энхийн төлөө цогцолбор ТӨААТҮГ-ын алба хаагчдыг сургалтад хамруулсан байна.	I-IV улиралд	Яам, харьяа байгууллагын Эрх бүхий албан тушаалтууд

1	2	3	4	5	6	7	8
2.4	Батлан хамгаалах салбарын хэмжээнд гадаадын зээл тусlamж болон төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд хариуцсан нэгжтэй уулзалт зохион байгуулах	Үйл ажиллагааны зардлаар	Уулзалт зохион байгуулсан тоо	2024 онд БХЯ, ЗХЖШЫН төсөл хөтөлбөр, зээл тусlamж, худалдан авах ажиллагаа хариуцсан нэгжийн бүрэлдэхүүнтэй 1 удаа уулзалт зохион байгуулсан байна.	Нэгдүгээр улирлын байдлаар: ҮБХИС-ийн төсөл хөтөлбөр, зээл тусlamж, худалдан авах ажиллагаа хариуцсан нэгжийн бүрэлдэхүүнтэй 1 удаа уулзалт зохион байгуулсан байна. Гуравдугаар улирлын байдлаар: Батлан хамгаалахын аж үйлдвэрийн нэгдэл Төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын төсөл хөтөлбөр, зээл тусlamж, худалдан авах ажиллагаа хариуцсан нэгжийн бүрэлдэхүүнтэй 1 удаа уулзалт зохион байгуулсан байна. Жилийн эцсийн байдлаар: Яамны харьяа 2 байгууллагын төсөл хөтөлбөр, зээл тусlamж, худалдан авах ажиллагаа хариуцсан нэгжийн бүрэлдэхүүнтэй 2 удаа уулзалт зохион байгуулсан байна.	I, III улиралд	ҮБХИС, БХАҮН-ийн Эрх бүхий албан тушаалтууд
2.5	Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулах бүх төрлийн гэрээнд хяналт тавих, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар тусгах	Үйл ажиллагааны зардлаар	Иргэд, аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний тоо	Батлан хамгаалах яам 2024 онд нийт 44 арга хэмжээний 174 багц тендерт шалгарсан байгууллагуутдай 216 гэрээ байгуулан ажилласан.	Хагас жилийн байдлаар: Яам, харьяа байгууллагаас зарласан тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй байгуулах бүх төрлийн гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар тусгагдсан байна.	I, III улиралд	Яамны БХЗГ, тендер шалгаруулалт зохион байгуулж, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан

1	2	3	4	5	6	7	8	
					<p>Жилийн эцсийн байдлаар: Яам, харьяа байгууллагаас зарласан тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй байгуулах бүх төрлийн гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар тусгагдсан байна. Гэрээ байгуулсан, гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар тусгагдсан нотлох баримт, тоог яамны ЭБАТ-д хагас, бүтэн жилээр ирүүлсэн байна.</p>			харьяа байгууллагууд

Гурав. Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх, ил тод байдлыг сайжруулах

3.1	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Олон нийттэй харилцах төвийн 11-11 тусгай дугаар, Батлан хамгаалах яамны тусгай дугаар "1800-1144", 11458929 дугаарт иргэд, төрийн байгууллага, албан тушаалтнаас гаргасан санал, хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх	Үйл ажиллагааны зардлаар	Өргөдөл, гомдол, санал, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн тоо	2024 онд ОНХТ-ийн 11-11 тусгай дугаарт 128, яамны 1800-1144 тусгай дугаарт 72, 11458929 дугаарт 84, нийт 284 өргөдөл, гомдол, санал, хүсэлт, талархал ирүүлснийг шийдвэрлэж ажилласан байна.	<p>Хагас жилийн байдлаар: Яам, харьяа байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан байна.</p> <p>Жилийн эцсийн байдлаар: Яам, харьяа байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан байна. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаарх нотлох баримт, тоог хагас, бүтэн жилээр гаргаж яамны ЭБАТ-д ирүүлсэн байна.</p>	I-IV улиралд	Яамны өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэн болон харьяа байгууллагын өргөдөл, гомдол хариуцсан албан тушаалтан
-----	--	--------------------------	---	--	---	--------------	---


1	2	3	4	5	6	7	8
3.2	Яам, харьяа байгууллагууд үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах	Үйл ажиллагааны зардлаар	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шилэн дансанд оруулсан мэдээллийн тоо	2024 онд яам, харьяа байгууллагууд шилэн дансанд хуулийн хугацаанд мэдээллийг оруулсан байна.	Хагас жилийн байдлаар: Яам, харьяа байгууллагаас шилэн дансанд хуулийн хугацаанд мэдээллийг оруулсан байна. Жилийн эцсийн байдлаар: Яам, харьяа байгууллагаас шилэн дансанд хуулийн хугацаанд мэдээллийг оруулсан байна. Шилэн дансанд оруулсан мэдээллийн талаарх нотлох баримт, тоог хагас, бүтэн жилээр гаргаж яамны ЭБАТ-д ирүүлсэн байна.	I-IV улиралд	Яамны ХШУДАГ, СХОГ, яамны харьяа байгууллагын холбогдох албан тушаалтнууд

Дөрөв. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх

4.1	Авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах, үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндэрэл, бэрхшээлийг тодорхойлох судалгааг авч, дүгнэлт гаргасан байна.	Тандалт, судалгаанд шаардагдах бичиг хэргийн материалын зардлаар	Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн тоо	2024 онд яам, харьяа байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдээс судалгаа авч байгаагүй.	Нэгдүгээр улирлын байдлаар: Байгууллага бүр үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндэрэл, бэрхшээлийг тодорхойлох судалгааг авч, дүгнэлт гаргасан байна. Хоёрдугаар улирлын байдлаар: Цэргийн төв эмнэлгээр үйлчлүүлж байгаа иргэдээс тандалт судалгааг авч, дүгнэлт гаргасан байна. (яамнаас томилогдсон бүрэлдэхүүн) Нэгдүгээр улирлын байдлаар: Байгууллага бүр үйлчлүүлэгчдээс	II, IV улиралд	БХЕШ-ийн Ажлын алба, ХШУДАГ, яамны Эрх бүхий албан тушаалтан, харьяа байгууллагын холбогдох албан тушаалтнууд
-----	---	--	---	--	---	-------------------	---

1	2	3	4	5	6	7	8
					<p>авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндэрэл, бэрхшээлийг тодорхойлох судалгааг авч, дүгнэлт гаргасан байна.</p> <p>Дөрөвдүгээр улирлын байдлаар: Батлан хамгаалахын төв архиваар үйлчлүүлж байгаа иргэдээс тандалт судалгааг авч, дүгнэлт гаргасан байна. (яамнаас томилогдсон бүрэлдэхүүн)</p> <p>Жилийн эцсийн байдлаар: Судалгааг нэгтгэн, дүгнэлт гаргаж, АТГ-т хүргүүлсэн байна.</p>		

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА  Ц.ОДХҮҮ

БОЛОВСРУУЛСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ, ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН
ДЭД ХУРАНДАА  Х.МӨНХЗАЯА